



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/492

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн суманд ашиглагдаж байгаа хяналтын камерын эрчим хүчний 2023 хагас жилийн төлбөрт 1,683,334 (Нэг сая зургаан зуун наян гурван мянга гурван зуун гучин дөрвөн) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 1,683,334 (Нэг сая зургаан зуун наян гурван мянга гурван зуун гучин дөрвөн) төгрөгийг аймгийн Засаг дарга дансанд батлагдсан "Гудамжны хяналтын камерын кабелийн худаг, сувагчлал, агаарын баганын түрээс, цахилгааны төлбөрийн зардал"-аас гаргаж зарцуулахыг төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа А.Алтанцоож)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ